

Бүтцэн хамаарал (Structure-Dependency)-ыг Монгол-Англи орчуулгад ашиглахын учир холбогдол

Ц. Отгонсүрэн
МУИС. МХСС

Өдгөө залууст гадаад хэлийг төгс эзэмшин, тухайн хэлнээс эх хэл рүүгээ, эх хэлнээс судалж буй гадаад хэл рүү аман болон бичгийн орчуулга хийх хүсэл сонирхол хийгээд хэрэгцээ шаардлага зүй ёсоор тавигдаж, тэрхүү үйл явц улам бүр түргэсэх болсныг өнөөгийн даяаршлын нийгэмтэй холбон тайлбарлах нь илүүд зүйд нийцэх болов уу. Гэвч тэрхүү гадаад хэлийг яаж төгс эзэмших вэ? Орчуулгыг хэрхэн төгс хийж сурах вэ? гэдэг нь гадаад хэл суралцагсдын байнгын бясалгаж, түүндээ хариулт эрэлхийлдэг асуудлын нэг билээ. Ер нь орчуулга хийнэ гэдэг бол аливаа дохиог нэг хэлнээс нөгөө хэл рүү илэрхийлэн буулгах буюу нэг тэмдэгтээс нөгөө тэмдэгт рүү шилжүүлж буй үйл ажиллагаа бөгөөд орчуулагчаас хоёр хэлний өндөр мэдлэгийг шаарддаг. Ингэх нь зүйн хэрэг ч түүнийг эзэмших арга зам нэн чухал юм.

Одоогоос 50 жилийн тэртээ буюу 1957 онд Америкийн нэрт хэлшинжээч Наом Чомский (Naom Chomsky) “Дэлхий дээрх хүний хэлнүүдэд тэдгээрийн төрөл ба төрөл бус хэл гэдгээс үл хамаарсан нийтлэг, ижил төстэй шинж байна”¹ хэмээн тодорхойлсон хэлний мэдлэгийн тухай онолыг “Түгээмэл хэлзүй” (Universal Grammar) нэртэйгээр боловсруулсан агаад өдгөө Америк, Япон болон барууны зарим оронд голлон баримталдаг хэлшинжлэлийн онол болтлоо хөгжжээ. Энэ онол нь “...1930-аад оны үеэс хэлшинжлэлд гарч ирсэн онол-аргазүйн нэг чухал баримтлал бол өгүүлбэр нь үгсээс бус харин үгсийг бүтцийнх нь талаас бүлэглэсэн хэлцүүдээс тогтдог гэж үзэх болсон явдал бөгөөд эл зарчим дээр үндсэндээ тулгуурлагдсан”² учир энд онцлон өгүүлэх эл аргыг “монгол-англи орчуулгад ашиглахын учир холбогдол”-ыг улам тодорхой болгож байна. Гэхдээ энэ онол Монгол хэлшинжлэлд цоо шинээр орж ирж буй онол биш бололтой. Учир нь манай нэртэй хэлшинжээч, эрдэмтдийн судалгааны ажил нэн ялангуяа өгүүлбэрзүйн ном, зохиолд үүнтэй ижил төстэй үг, өгүүлбэр чамгүй ажиглагддагийг дурдалтай. Тухайлбал Акад. Ш. Лувсанвандан “Монгол хэлний бүтэц” зохиолдоо хэл, хэлэхүйн асуудлыг гаргаж, хооронд нь ялгаж салган ойлгох хэрэгтэйг онцолсон бол “Монгол хэлний үгүүлбэрзүйн асуудал” эмхтгэлдээ өгүүлбэрийг бүтцийн талаас судалгаа хийн өгүүлбэрийн доторхи үг бүрийг салгах бус харин хооронд нь холбож үзэх нь оновчтой арга хэмээн үзжээ. Харин Д-р. Проф. Пүрэв-Очир “Орчин цагийн монгол хэлний өгүүлбэрзүй” номдоо монгол хэлний өгүүлбэрзүйн ангилал хийж дэлгэрэнгүй тайлбар сэлт оруулсан нь бий. Тэгэхээр энэ нь нэг талдаа монгол хэлшинжээчид энэ онолын талаар сонирхон судалж байсан, нөгөө талдаа энэ нь бас нэгэн хэлний нийтлэгийн илрэл гэж хэлж болохоор байна.

Бүтцэн хамаарал (Structure-Dependency) нь хэлнүүдийн нийтлэгийг илэрхийлэн гаргах зарчим юм. Түгээмэл хэлзүйн онолоор аливаа өгүүлбэрийн бүтцийн хувьд түүнийг бүрдүүлэгч нь хэлцүүдэд хуваагддаг бөгөөд тэдгээрийг “Хэлцэн бүтэц” (Phrase Structure) гэсэн ойлголтын доор тайлбарладаг. Тэрээр үгийн сангийн хувьд

¹ - Цэрэнпил. Д. *Гар бичмэл.*

² - Мөн тэнд

аливаа хэл хураагдан дөрвөн үндсэн хэлц (Үйлийн хэлц (VP), Нэрийн хэлц (NP), Тэмдэг нэрийн хэлц (AP), Залгаврын хэлц (PP)¹)-ээс тогтдог бөгөөд тэдгээр хэлцэн бүтцүүд нь цааш жижиг бүрэлдэхүүн хэсэг болон задрах бүрэн боломжтой гээд англи хэлний жишээн дээр авч үзсэн. Гэхдээ бид энд англи хэлийг **Нэг:** Түгээмэл хэлзүйн онол зохиогдсон суурь хэл; **Хоёр:** Дэлхий дахинаа хэрэглэгддэг хэл; **Гурав:** Бидний судлан үзэж буй хоёрдогч хэл болохын хувьд түүний өгүүлбэрзүйн бүтэц хийгээд үүсгэх зарчимд тулгуурлан орчуулга хийхэд бүтцийн хувьд нэн дөхөм болно гэсэн үүднээс хандан, жишээ болгон авлаа. Тэрхүү хэлцэн бүтцүүд тус бүртээ үүсгэх бүрдүүлэгчтэй байж болох бөгөөд заримаас нь монгол хэлтэй дүйцүүлэн харъя.

А. Үйлийн хэлц / Verb Phrase:

	Англи хэлнээ	Монгол хэлнээ
1.	V (to play, to smile)	V (тогло-, инээ-)
2.	V NP (to play basketball./to make friend)	NP V (сагсан бөмбөг тогло-/найз боло-)
3.	V Adj (to be new/to look nice)	Adj V (шинэ ажээ/байна/юм// сайхан харагда-)
4.	V NP PP (to give a ball to them)	PP NP V (тэдэнд бөмбөг өгө-)
5.	V PP NP (to give them a ball)	NP PP V (тэдэнд бөмбөг өгө-)
6.	V S (to say/to think that they are playing basketball)	S V (тэднийг сагсан бөмбөг тоглож байна гэж хэлэ-/бодо-)

Б. Нэрийн хэлц / Noun Phrase:

	Англи хэлнээ	Монгол хэлнээ
1.	N (child/ball)	N (хүүхэд//бөмбөг)
2.	Det N (the child)	D N (тэр хүүхэд) N D (хүүхэд нь/маань/чинь)
2.	Det NP (the children/boys)	Det NP (тэрхүү хүүхэд-үүд/хөвгүүн-д) NP Det (хүүхэд-үүд нь/ маань /чинь//хөвгүүн-д нь/ маань /чинь)
3.	Det Adj NP (the young children)	Det Adj NP (нөгөө жаахан хүүхэд-үүд) Adj NP Det (жаахан хүүхэд-үүд нь/ маань /чинь)
4.	NP N PP (the children's ball of basketball)	NP PP N (нөгөө хүүхдүүд-ийн сагсны бөмбөг) NP PP N Det (хүүхдүүд-ийн сагсны бөмбөг нь/ маань /чинь)
5.	Det NP S (the children who live here)	S Det NP (энд амьдардаг нөгөө хүүхдүүд) S NP Det (энд амьдардаг хүүхдүүд нь/ маань /чинь)
6.	Det N and N (the boys and girls)	Det N and N (нөгөө хөвгүүд охид) N and N Det (хөвгүүд охид нь/ маань /чинь)

В. Тэмдэг нэрийн хэлц / Adjective Phrase:

	Англи хэлнээ	Монгол хэлнээ
1.	Adj (nicely/new)	Adj (сайхан/шинэ)
2.	Adj and Adj (nice and new)	Adj and Adj (сайхан бөгөөд шинэ)
3.	V Adj (to look nice)	Adj V (сайхан харагда-)


Г. Залгаврын хэлц / Prepositional Phrase or Postpositional Phrase:

	Англи хэлнээ	Монгол хэлнээ
1.	PP NP (out of the door)	NP PP (хаалганы гадна)
2.	Adv (outside)	Adv (гадна)

¹ - VP-Verb Phrase; NP-Noun Phrase; AP-Adjective Phrase; PP-Prepositional/Postpositional Phrase.


Эдгээр нь англи хэлний “*The boys are playing basketball*” гэсэн хоёр бүрэлдэхүүнт өгүүлбэрийг жишээ болгон авч монгол хэлнээ орчуулан, модон дүрслэл болон тэмдэгт хаалтын загварт шилжүүлбээс тодорхой харагдана:

Англи хэлнээ:




[s[NP [D The] [NP boys]] [VP[VP are playing] [NP basketball.]]]

Монгол хэлнээ:



буюу [s[NP [D Нэгөө] [NP хөвгүүд]] [VP[NP сагсан бөмбөг] [VP тоглож байна.]] буюу




буюу [s[NP [NP Хөвгүүд] [D нь]] VP [NP сагсан бөмбөг] [VP тоглож байна]] гэсэн хэлцэн бүтцүүдээс бүрдэж байна. Гаднаас нь харахад энэхүү модон дүрслэл буюу тэмдэгт хаалтын загвар нь өгүүлбэрийн бүтцийг тодорхойлохын тулд өгүүлбэрийн гишүүдээр ялган зурдагтай төстэй мэт боловч зарчмын хувьд ялгаатай юм. Учир нь дээрхийн адилаар модон дүрслэл буюу тэмдэгт хаалтын загварт оруулснаар тухайн өгүүлбэр шугаман дараалал буюу хэвтээ тэнхлигийн хувьд бус босоо тэнхлэгийн үүднээс тайлбарлагдсанаар өгүүлбэрийн гишүүдийн харьцаа улам бүр тодорхой харагдаж байна. Өөрөөр хэлбэл “...Одоо зүйл бүрийн шинжлэх ухаан чухалчилж байгаа бүтэц зүйн үүднээс үзвэл хүний хэл нь олон давхарласан дохионы систем болно. Бүтэц зүйн үндсэн зарчим бол юм, үзэгдлийг бие биеэс нь таслахгүй холбож үзэхэд оршино. И. С. Трубецкой физик, хими, биологи зэргийн ухааныг хөгжихөд «тасалж үзэхийг холбож үзэхээр, салгаж үзэхийг түгээж үзэхээр солих» төстэй чиглэл гарч байгааг харуулж байна гэж онцлон тэмдэглэж байсан нь санамсаргүй зүйл биш юм”² хэмээн манай нэрт хэлшинжээч, Акад. Ш. Лувсанвандан бичсэн нь **Нэг**: энэ онол нь монгол хэлшинжлэлд онолын хувьд шинэ орж ирж буй онол хэдий ч энд яригддаг материал монгол хэлнээ

² -Лувсанвандан. Ш. *Монгол хэлний үгүүлбэрзүйн асуудлууд*. (Улаанбаатар. 2000) 154-р тал

хэзээнээсээ нааш байсаар ирсэн учраас үүнтэй ижил төстэйгээр авч үздэг байсан, **Хоёр:** өгүүлбэрийн бүрдүүлэгчийг дан дангаар нь салгаж үзэхээсээ илүүтэйгээр Нэрийн бүлэг, Үйлийн бүлэг³ болгон үзэх нь зөв зүйтэй болохыг нотлож байна.

Үүнээс гадна бидний уламжлалт хэлшинжлэл дэх “тусагдахуун” үйлийн хэлцтэй холбогдлоо гэж дээрхи жишээнээс ойлговол орон байр болон цаг хугацаа заасан “байц” аль хэлцэд харьяалагдах вэ? гэдэг асуулт гарч ирнэ. Тэгвэл үүнд монгол хэл ч бай, англи хэл ч бай ялгалгүй үйлийн хэлцэд холбогдоно гэсэн хариултыг өгнө. Учир нь эдгээр бүрдүүлэгч нэрийн хэлцтэй холбогдох үндэс үгүй. Өөрөөр хэлбэл монгол хэлэнд үйлийн эзнийг шаардалгүйгээр “Хаана тоглож байна вэ?” гэж асуухаас “Хөвгүүд хаана...?”⁴ гэж үйл үгийг нь орхин асуудаггүй. Харин англи хэлэнд үйлийн эзнийг оруулан асуудаг ч тэр нь “хаана-where” “хэзээ-when” гэсэн асуух төлөөний үгтэй төдийлэн холбогдолгүй юм. Энэ тухай Д-р. Проф. Пүрэв-Очир “... Монгол хэлний байц, шууд бус тусагдахуун хоёрт төсөөтэй шинжүүд байдаг бөгөөд энэ нь дэлхийн бусад хэлнүүдэд ч байдаг. Өгүүлбэрийн бүтцэд байрлахдаа тухайн өгүүлбэрийн өгүүлэхүүн бүлгийн дагуул болж, утга, үүргээрээ өгүүлэхүүнийг нэмэн дэлгэрүүлж, улмаар өгүүлэхүүнээс ногдох асуултын тусламжтайгаар илэрдгээрээ төстэй. Ер нь байц, тусагдахуун хоёул үйлийн холбоо үгэнд суурилсан байдаг”⁵ гэж бичсэн нь бий. Үүнд жишээ болгож дээрх өгүүлбэрээ “*The boys are playing basketball outside now.*” гэж дэлгэрүүлэн модон дүрслэл болон тэмдэгт хаалтын загварт шилжүүлбээс:

Англи хэлнээ:




буюу [s[NP [D The][NP boys]] [VP[VP are playing][NP basketball][AP outside][AP now]]]

Монгол хэлнээ:


³ -Пүрэв-Очир. Б. *Орчин цагийн монгол хэлний өгүүлбэрзүй I*. (Улаанбаатар: Мөнхийн үсэг. 2001) 225-р талд ийн нэр томъёо оноожээ.

⁴ - Энэ мэт төгсгөл үгүй асуултыг асуух явцад өөр хэн нэгэн саатуулсан, сарниасан тохиолдолд л байх боломжтой мэт.

⁵ - Пүрэв-Очир. Б. *Орчин цагийн монгол хэлний өгүүлбэрзүй I*. (Улаанбаатар: Мөнхийн үсэг. 2001) 178-р талд



буюу [S[NP [D Нөгөө] [NP хөвгүүд]] [VP [AP одоо][AP гадаа][NP сагсан бөмбөг][VP тоглож байна]]] эсвэл



буюу [S[NP [NP Хөвгүүд] [D нь]] [VP [AP одоо][AP гадаа][NP сагсан бөмбөг][VP тоглож байна]]]

гэсэн хэлцэн бүтцүүдээс бүрдэж байна.

Бид нэгэнтээ өгүүлбэрээ хэлцэн бүтцэд хурааснаар 5, 10, 15, 20 бүр түүнээс олон үгнээс бүтсэн урт өгүүлбэр ч байсан ямар нэгэн шилжилт⁶ хөдөлгөөн, өгүүлбэрзүйн хувиргалт хийхэд хялбар боллоо гэсэн үг. Өөрөөр хэлбэл өгүүлбэрийн шугаман дарааллыг өөрчлөх бус бүтцийн махбодиудын дарааллыг өөрчлөн хүний хэлний бүтцийг өөрчилж болдог байна. Чухамхүү энэ л орчуулга хийхдээ ашиглах бидний тулгуур ойлголт, үндсэн баримтлал болох юм.

Тэгвэл дээрх өгүүлбэрийн бүрдүүлэгчийг дэлгэрүүлэн үзье.

1. *The boys are playing. Нөгөө хөвгүүд тоглож байна.*
2. *The boys are playing basketball. Нөгөө хөвгүүд сагсан бөмбөг тоглож байна.*
3. *The boys are playing basketball outside. Нөгөө хөвгүүд гадаа сагсан бөмбөг тоглож байна.*
4. *The boys are playing basketball outside now. Нөгөө хөвгүүд одоо гадаа сагсан бөмбөг тоглож байна.*
5. *The boys who have lived here for ten years are playing basketball outside now. Энд арван жил хиртээ амьдарч байгаа нөгөө хөвгүүд одоо гадаа сагсан бөмбөг тоглож байна.*


⁶ -Movement буюу шилжилт хөдөлгөөн гэдэг нь энэ онолын бас нэгэн чухал хэсэг юм.

6. *The boys who have lived here with their parents for ten years are playing basketball-a kind of games which every youth likes outside now.* Энд арван жил хиртээ аав ээжтэйгээ хамт амьдарч байгаа нөгөө хөвгүүд одоо гадаа залуус бүхний тоглох дуртай спортын төрөл болох сагсан бөмбөг тоглож байна.

Энэ мэтээр өгүүлбэр тэх бүрдүүлэгчийг дэлгэрүүлбэл үлэмж урт өгүүлбэр бүтэж болохуйц байна. Харин одоо дээрхи өгүүлбэрүүдээ дэлгэрүүлэх бус асуулт болгон хувиргаж үзье.

1. *Are the boys playing?*- Нөгөө хөвгүүд тоглож байна уу?
2. *Are the boys playing basketball?*- Нөгөө хөвгүүд сагсан бөмбөг тоглож байна уу?
3. *Are the boys playing basketball outside?* – Нөгөө хөвгүүд гадаа сагсан бөмбөг тоглож байна уу?
4. *Are the boys playing basketball outside now?*- Нөгөө хөвгүүд одоо гадаа сагсан бөмбөг тоглож байна уу?
5. *Are the boys who have lived here for ten years playing basketball outside now?*-Энд арван жил хэртээ амьдарч байгаа нөгөө хөвгүүд одоо гадаа сагсан бөмбөг тоглож байна уу?
6. *Are the boys who have lived here with their parents for ten years playing basketball-a kind of games which every youth likes outside now?*-Энд аав ээжтэйгээ арван жил хэртээ амьдарч байгаа нөгөө хөвгүүд одоо гадаа залуусын дуртай сагсан бөмбөг тоглож байна уу?

Үнэндээ Чомский “*The man who is tall is John*”⁷ гэсэн жишээ авч шилжилт хийхэд аль “is” нь хөдлөх вэ? гэдэг асуултад эхний “is”, эс бөгөөс хоёрдахь “is” гэхээсээ илүү өгүүлбэрийг бүрдүүлэгч гол үйлийн хэлцийн бүрдүүлэх туслах үйл үг “is” нь хөдөлнө гэсэн хариулт өгсөн. Үүнийг батлахын тулд модон дүрслэлийн хэлбэрт шилжүүлэн ажиглая.



⁷ - Vivian Cook, Mark Newson. *Chomsky's Universal Grammar: An Introduction*. Second Edition. (Beijing: Foreign Language Teaching and Research Press. 2000) p8.

Тэгэхээр гол өгүүлбэрийг бүрдүүлэгч нэрийн болон үйлийн хэлцийн махбодуудыг шилжилт хөдөлгөөнд оруулна. Харин “*who is tall*” гэсэн гишүүн өгүүлбэр нь гол өгүүлбэрийн нэрийн хэлцийн бүрдүүлэгчийг тодотгож буй учир шилжилт хөдөлгөөнд орохгүй нь харагдаж байна.

↓ *The man who is tall is John.* —> *Is the man who is tall John?*

Тэгэхлээр өгүүлбэрт хэчнээн тодотгогч байсан ч англи хэлэнд гол өгүүлбэрийн нэр үг хийгээд үйл үг шилжилт хөдөлгөөнд ордог. Харин монгол хэлний хувьд өөр. Монгол хэлэнд энэ мэтийн өгүүлбэрзүйн шилжилт хөдөлгөөн ажиглагдахгүй, харин асуух өгүүлбэрийн эцэст “уу/үү, бэ/вэ” гэх мэт махбодыг хэрэглэсэн байна. Тиймээс монгол хэл бол шилжилт хөдөлгөөнгүй хэлэнд тооцогдох төдийгүй үг, өгүүлбэрийн ард тухайн утга илтгэх махбод залгахад англи хэлний шилжих хөдөлгөөнийг илэрхийлэн гаргаж чадаж байна.

Үүнийг өөр нэг шилжилт хөдөлгөөн дээр тайлбарлая. Өмнө нь жишээ болгон авсан үндсэн өгүүлбэр шууд тусагдахуунтай өөрөөр хэлбэл тусах өгүүлбэр учир үүнийг идэвхгүй хэвд шилжүүлэхэд тодорхой харагдана. (*Жич: Англи хэлний жишээ өгүүлбэрийг монгол хэлтэй хадаж, дүйлгэн, хэлзүйн тайлбарлал хийх гэснээс үүдэн монгол хэлний найруулга нь хэтэрхий үгчилсэн, үхмэл болсныг болгооно уу.*)

1. no case
2. ***Basketball is being played by the boys.*** *Сагсан бөмбөг нөгөө хөвгүүд-ээр тоглогдож байна.*
3. ***Basketball is being played by the boys outside.*** *Сагсан бөмбөг нөгөө хөвгүүд-ээр гадаа тоглогдож байна.*
4. ***Basketball is being played by the boys outside now.*** *Сагсан бөмбөг нөгөө хөвгүүд-ээр одоо гадаа тоглогдож байна.*
5. ***Basketball is being played by the boys who have lived here for ten years outside now.*** *Сагсан бөмбөг энд арван жил хиртээ амьдарч байгаа нөгөө хөвгүүд-ээр одоо гадаа тоглогдож байна.*
6. ***Basketball—a kind of games which every youth likes is being played by the boys who have lived here with their parents for ten years outside now.*** *Залуусын дуртай сагсан бөмбөг энд аав ээжтэйгээ арван жил хиртээ амьдарч байгаа нөгөө хөвгүүд-ээр одоо гадаа тоглогдож байна.*

Энэ мэтчилэн цааш монгол өгүүлбэрийг хүний хэлний өгүүлбэрийн олон хэв шинжид хувиргаж болохоор байна. Өөрөөр хэлбэл тухайн өгүүлбэрийн гол хоёр хэлцэн бүтцийг зөв тодорхойлж чадвал хэлцийг бүхлээр нь зөөгөөд ямар ч өгүүлбэрийн загварт оруулж болно гэсэн үг. Тэгэхлээр нэгэнтээ бид орчуулга хийх үндсэн зарчмыг ойлгосноос хойш одоо үгээ зөв сонгож, түүнээ хэлзүйн дүрмийн дагуу зөв хувиргах л үлдлээ.

Ном зүй

1. Jamal Ouhalla. *Introducing Transformational Grammar: From Principles and Parameters to Minimalism*. Second Edition. (Beijing: Foreign Language Teaching and Research Press. 2001) p18-40.
2. Laura Wright and Jonathan Hope. *Stylistics*. A practical coursebook. (London and New York: Routledge Taylor & Francis Group) 233р.
3. Лувсанвандан. Ш. *Монгол хэлний үгүүлбэрзүйн асуудлууд*. (Улаанбаатар. 2000)
4. Пүрэв-Очир. Б. *Орчин цагийн монгол хэлний өгүүлбэрзүй*. (Улаанбаатар: Мөнхийн үсэг. 2001)
5. Цэрэнпил. Д. *Гар бичмэл*.
6. Vivian Cook & Mark Newson. *Chomsky's Universal Grammar: An Introduction*. Second Edition. (Beijing: Foreign Language Teaching and Research Press. 2000) 350р.

Товчилсон нэрний жагсаалт

S-Sentence

V-Verb (Үйл үг дангаараа байвал)

VP-Verb Phrase (Хэд хэдэн үйл үг, эсвэл ямар нэгэн баймжийн утга хамт орсон бол)

N-Noun (Нэр үг дангаараа байвал)

NP-Noun Phrase (Нэр үг дангаараа бус, өөр бусад үгтэй хоршин орсон, өгүүлэгдэхүүн гишүүн өгүүлбэр, хэлцээс бүтсэн байвал)

PP-Prepositional Phrase (Угтвар дангаараа бус нэр үгтэй хам орсон бол)

Adj-Adjective (Тэмдэг нэр дангаараа байвал)

AP-Adjective Phrase (Тэмдэг нэр дангаараа бус хэлцээрээ байвал)

Adv-Adverb (Дайвар үг дангаараа байвал)

Det/D-Determiner (Тодотгогч)

Summary

In this article, the author is trying to explain the significance or advantage of Universals, drawing on the principle of English syntax as well as the experience⁸ of teaching Mongolian-English translation and to make some conclusions like the following:

1. Although this theory is new in Mongolian linguistics, each material, mentioned in this theory, has been kept in Mongolian language and studied. Judging from this, it is an evidence of language universals.
2. When a learner or translator knows about the universals between his or her own native language and any other foreign languages, it cannot be so difficult to learn or teach foreign language and translate or interpret from one into others.
3. Translation could be good, if it is made on the basis of defining some phrase-structures in a sentence.

⁸ - Монгол-Англи орчуулгын хичээлд хэлцэн бүтцийн зарчмыг баримтлан хэд хэдэн өгүүлбэр орчуулж туршсан бөгөөд суралцагсад өгүүлбэрийн бүтцийг зөв илэрхийлэн гаргаж, нийлмэл өгүүлбэрийг орчуулахад хялбар дөхөм арга болж чадаж байсныг энд тэмдэглүүштэй.